

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Өргөө амаржих газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХАК-2022/794/НА-СА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2022 он</p>	<p>"Монголиан бизнес рейтинг-Аудит" ХХК Захирал: Д.Түмэнжаргал Утас: 7000-5329 Цахим хаяг: mbr.audit.llc@gmail.com "Монголиан бизнес рейтинг -Аудит" ХХК Аудитын менежер: Н.Алтанзул Утас: 80825909 Цахим хаяг: mbr.audit.llc@gmail.com Аудитор: Б.Солонготуяа Утас: 99595909 Цахим хаяг: mbr.audit.llc@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.9.2 Бусад хууль тогтоомжтой холбоотой.....	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	0

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
НӨАГ	Нийслэлийн Өргөө амаржих газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.02.25 № 469

танай _____-ны № _____-Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Өргөө амаржих газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Өргөө амаржих газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	748,017,943.82	1,460,504,936.48
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	20,978,546.83
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	20,978,546.83
3121	Төгрөг	-	20,978,546.83
31211	Төрийн сангийн харилцах	-	10,878,546.83
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	10,100,000.00
33	АВЛАГА	9,509,786.00	641,210,165.81
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	629,849,808.00
335	Бусад авлага	9,509,786.00	11,360,357.81
3351	Байгууллагаас авах авлага	9,509,786.00	11,360,357.81
35	БАРАА МАТЕРИАЛ	738,508,157.82	798,316,223.84
351	Түүхий эд материал	218,020,082.66	208,129,747.29
35130	Эм боох материал	218,020,082.66	208,129,747.29
354	Хангамжийн материал	520,488,075.16	590,186,476.55
35410	Бичиг хэргийн материал	3,926,571.00	4,959,763.00
35420	Аж ахуйн материал	9,399,674.00	5,996,190.00
35430	Сэлбэг хэрэгсэл	16,504,700.00	22,866,324.00
35440	Түлш, шатах тослох материал	186,977.01	183,396.22
35450	Барилгын засварын материал	273,460.00	-
35470	Бусад хангамжийн материал	490,196,693.15	556,180,803.33
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,156,465,441.10	20,355,503,161.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,156,465,441.10	20,355,503,161.08
392	Биет хөрөнгө	19,712,060,951.10	19,911,152,421.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	18,272,810,256.30	18,369,868,011.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(809,253,436.74)	(1,350,692,619.90)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	103,300,000.00	103,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(72,799,999.92)	(82,966,666.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,493,730,328.43	8,327,430,727.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,417,740,943.27)	(5,585,985,831.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	510,449,649.09	521,315,773.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	(391,520,723.75)	(412,688,260.64)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,000,000.00	3,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,145,329.00	15,145,329.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,271,799.44)	(3,786,332.40)
39217	Ном	7,212,291.40	7,212,291.40
393	Биет бус хөрөнгө	444,404,490.00	444,350,740.00
39301	Програм хангамж	2,021,500.00	2,021,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,967,750.00)	(2,021,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	444,350,740.00	444,350,740.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	20,904,483,384.92	21,816,008,097.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	162,060,897.00	1,003,568,742.72
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	162,060,897.00	1,003,568,742.72
413	Өглөг	162,060,897.00	1,003,568,742.72
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	133,788,528.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	981,230,902.72
4136	Бусад өглөг	28,272,369.00	22,337,840.00
41361	Байгууллагад төлөх өглөг	28,272,369.00	22,337,840.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	20,742,422,487.92	20,812,439,354.84
51	Засгийн газрын хувь оролцоо	20,742,422,487.92	20,812,439,354.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,619,067,752.19	5,619,067,752.19
51101	Өмч: - төрийн	5,619,067,752.19	5,619,067,752.19

512	Хуримтлагдсан үр дүн	6,262,966,009.18	6,333,029,312.62
51210	Өмнөх үеийн үр дүн	6,262,966,009.18	6,263,012,445.70
51220	Тайлант үеийн үр дүн	-	70,016,866.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,860,388,726.55	8,860,342,290.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>20,904,483,384.92</u>	<u>21,816,008,097.56</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	13,203,971,570.45	16,100,144,539.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,404,126,162.45	2,303,999,076.35
120	Нийтлэг татварын бус орлого	707,555,461.95	887,754,405.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	707,555,461.95	887,754,405.72
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	479,903,566.25	378,344,514.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	74,293,128.80	63,647,059.16
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	153,358,766.90	445,762,832.56
122	Тусламжийн орлого	696,570,700.50	1,416,244,670.63
122001	Хандив тусламж /дотоод/	696,570,700.50	1,416,244,670.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,799,845,408.00	13,796,145,463.46
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,246,728,200.00	1,520,115,860.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,246,728,200.00	1,520,115,860.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,779,294.00	1,034,826,693.46
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,000,000.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,156,434.00	1,025,738,304.46
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,622,860.00	7,088,389.00
1330	Төсвийн захирагчдаас	-	1,655,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	150,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	-	1,505,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,524,337,914.00	9,586,202,910.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,524,337,914.00	9,586,202,910.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,532,395,287.22	16,030,127,672.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,532,395,287.22	16,030,127,672.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,511,532,958.95	15,397,334,195.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,701,411,457.99	8,355,786,957.63
210101	Үндсэн цалин	6,725,566,893.99	5,323,227,821.63
210102	Нэмэгдэл	-	2,099,768,768.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	464,422,013.00	403,270,000.00
210104	Урамшуулал	511,422,551.00	529,520,368.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	988,013,599.37	1,118,675,749.57
210201	Тэтгэврийн даатгал	683,629,992.37	795,094,947.63

Нийслэлийн Өргөө амаржих газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	80,421,048.00	86,655,011.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	61,843,721.00	65,182,382.75
210204	Ажилгүйдлийн даатгал	14,647,464.00	15,527,538.77
210205	Эрүүл мэндийн даатгал	147,471,374.00	156,215,868.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	425,487,035.00	524,168,796.50
210301	Гэрэл, цахилгаан	192,137,316.00	189,301,730.68
210302	Түлш, халаалт	102,372,266.00	119,732,129.82
210303	Цэвэр, бохир ус	130,977,453.00	215,134,936.00
2104	Хангамж, бараа материалын зардал	324,407,012.01	311,344,342.37
210401	Бичиг хэрэг	17,675,705.50	22,417,951.00
210402	Тээвэр, шатахуун	7,822,955.59	11,314,358.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,904,507.42	13,288,865.09
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	136,016,242.00	148,666,594.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	412,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	151,575,601.50	115,656,573.30
2105	Нормативт зардал	2,764,860,574.22	3,612,419,339.17
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,374,961,074.22	3,034,043,299.17
210502	Хоол, хүнс	389,899,500.00	578,376,040.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,005,440.00	129,815,380.00
210604	Урсгал засвар	39,005,440.00	129,815,380.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	95,344,544.00	90,272,370.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,566,910.00	57,230,350.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	429,300.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	221,100.00	291,191.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	-
210807	Газрын төлбөр	2,879,500.00	2,879,520.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	939,600.00	29,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	29,242,134.00	21,841,809.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,173,003,296.36	1,254,851,260.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,884,496.00	3,560,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,038,700.00	9,033,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,158,080,100.36	1,242,257,760.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,862,328.27	632,793,477.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,311,937.00	632,793,477.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,311,937.00	632,793,477.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,550,391.27	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,550,391.27	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(328,423,716.77)	70,016,866.92
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(328,423,716.77)	70,016,866.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>12,352,107,323.05</u>	<u>13,601,671,971.62</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	552,261,915.05	435,376,316.16
120	Нийтлэг татварын бус орлого	552,261,915.05	435,376,316.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	552,261,915.05	435,376,316.16
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	479,903,566.25	378,344,514.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	72,358,348.80	57,031,802.16
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,799,845,408.00	13,166,295,655.46
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,246,728,200.00	1,520,115,860.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,246,728,200.00	1,520,115,860.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,779,294.00	1,034,826,693.46
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,000,000.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,156,434.00	1,025,738,304.46
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,622,860.00	7,088,389.00
1330	Төсвийн захирагчдаас	-	1,655,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	150,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	-	1,505,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,524,337,914.00	8,956,353,102.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,524,337,914.00	8,956,353,102.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>12,330,019,723.05</u>	<u>13,555,642,614.79</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,330,019,723.05	13,555,642,614.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,309,157,394.78	12,922,849,137.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,567,622,929.99	8,509,587,878.73
210101	Үндсэн цалин	4,028,000,841.95	4,315,784,562.73
210102	Нэмэгдэл	2,372,788,076.89	2,997,042,777.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	562,797,012.00	561,888,595.00
210104	Урамшуулал	604,036,999.15	634,871,944.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	988,013,599.37	1,100,086,749.47
210201	Тэтгэврийн даатгал	683,629,992.37	776,505,947.63
210202	Тэтгэмжийн даатгал	80,421,048.00	86,655,011.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	61,843,721.00	65,182,382.75
210204	Ажилгүйдлийн даатгал	14,647,464.00	15,527,538.77
210205	Эрүүл мэндийн даатгал	147,471,374.00	156,215,868.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	425,487,035.00	524,168,796.50
210301	Гэрэл, цахилгаан	192,137,316.00	189,301,730.68
210302	Түлш, халаалт	102,372,266.00	119,732,129.82
210303	Цэвэр, бохир ус	130,977,453.00	215,134,936.00
2104	Хангамж, бараа материалын зардал	186,979,728.42	218,516,957.09

Нийслэлийн Өргөө амаржих газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	14,388,410.50	19,552,842.00
210402	Тээвэр, шатахуун	10,499,100.00	9,480,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,904,507.42	13,288,865.09
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	142,276,335.00	142,722,670.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,911,375.50	33,472,080.00
2105	Нормативт зардал	2,716,868,890.00	2,355,523,905.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,208,908,371.00	1,767,645,375.00
210502	Хоол, хүнс	434,825,400.00	535,011,630.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	73,135,119.00	52,866,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,182,850.00	104,264,730.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,986,450.00	1,240,000.00
210604	Урсгал засвар	28,196,400.00	103,024,730.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,416,085.00	91,838,251.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,566,910.00	57,175,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	429,300.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	221,100.00	291,191.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	-
210807	Газрын төлбөр	2,879,500.00	2,879,520.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	939,600.00	29,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	33,313,675.00	23,462,090.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	291,586,277.00	18,861,870.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	287,692,577.00	9,365,270.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,893,700.00	9,496,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,862,328.27	632,793,477.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,311,937.00	632,793,477.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,311,937.00	632,793,477.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,550,391.27	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,550,391.27	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>22,087,600.00</u>	<u>46,029,356.83</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,087,600.00	25,050,810.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,087,600.00	25,050,810.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,087,600.00	25,050,810.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,087,600.00	25,050,810.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(22,087,600.00)</u>	<u>(25,050,810.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	20,978,546.83
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,978,546.83

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,619,067,752.19	8,860,319,676.57	6,743,850,248.86	21,223,237,677.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,619,067,752.19	8,860,319,676.57	6,743,850,248.86	21,223,237,677.62
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(328,423,716.77)	(328,423,716.77)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,619,067,752.19	8,860,388,726.55	6,262,966,009.18	20,742,422,487.92
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	5,619,067,752.19	8,860,388,726.55	6,262,966,009.18	20,742,422,487.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	46,436.52	46,436.52
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,619,067,752.19	8,860,388,726.55	6,263,012,445.70	20,742,468,924.44
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(46,436.52)	-	(46,436.52)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	70,016,866.92	70,016,866.92
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,619,067,752.19	8,860,342,290.03	6,333,029,312.62	20,812,439,354.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,770,005,200.00	12,555,966,731.33	(214,038,468.67)	98%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,770,005,200.00	12,555,966,731.33	(214,038,468.67)	98%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,761,365,200.00	12,551,473,254.33	(209,891,945.67)	98%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,173,249,000.00	8,170,712,176.73	(2,536,823.27)	100%
210101	Үндсэн цалин	4,232,478,900.00	3,976,908,860.73	(255,570,039.27)	94%
210102	Нэмэгдэл	2,743,413,100.00	2,997,042,777.00	253,629,677.00	109%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	562,485,000.00	561,888,595.00	(596,405.00)	100%
210104	Урамшуулал	634,872,000.00	634,871,944.00	(56.00)	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,056,677,000.00	1,056,676,928.01	(71.99)	100%
210201	Тэтгэврийн даатгал	743,587,500.00	733,096,126.17	(10,491,373.83)	99%
210202	Тэтгэмжийн даатгал	78,272,400.00	86,655,011.56	8,382,611.56	111%
210203	ҮОМШӨ-ний даатгал	62,617,900.00	65,182,382.75	2,564,482.75	104%
210204	Ажилгүйдлийн даатгал	15,654,500.00	15,527,538.77	(126,961.23)	99%
210205	Эрүүл мэндийн даатгал	156,544,700.00	156,215,868.76	(328,831.24)	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	525,161,400.00	524,168,796.50	(992,603.50)	100%
210301	Гэрэл, цахилгаан	236,075,800.00	189,301,730.68	(46,774,069.32)	80%
210302	Түлш, халаалт	148,510,200.00	119,732,129.82	(28,778,070.18)	81%
210303	Цэвэр, бохир ус	140,575,400.00	215,134,936.00	74,559,536.00	153%
2104	Хангамж, бараа материалын зардал	218,647,400.00	218,516,957.09	(130,442.91)	100%
210401	Бичиг хэрэг	13,191,000.00	19,552,842.00	6,361,842.00	148%
210402	Тээвэр, шатахуун	12,500,000.00	9,480,500.00	(3,019,500.00)	76%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,899,200.00	13,288,865.09	389,665.09	103%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	162,623,900.00	142,722,670.00	(19,901,230.00)	88%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,433,300.00	33,472,080.00	16,038,780.00	192%
2105	Нормативт зардал	2,561,059,500.00	2,355,523,905.00	(205,535,595.00)	92%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,019,373,000.00	1,767,645,375.00	(251,727,625.00)	88%
210502	Хоол, хүнс	466,010,900.00	535,011,630.00	69,000,730.00	115%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	75,675,600.00	52,866,900.00	(22,808,700.00)	70%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	124,597,000.00	124,539,640.00	(57,360.00)	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,375,000.00	20,274,910.00	(100,090.00)	100%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	1,240,000.00	(3,760,000.00)	25%
210604	Урсгал засвар	99,222,000.00	103,024,730.00	3,802,730.00	104%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,407,500.00	91,838,251.00	(569,249.00)	99%

Нийслэлийн Өргөө амаржих газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,200,000.00	57,175,950.00	(24,050.00)	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	28,000.00	-	(28,000.00)	0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	540,000.00	291,191.00	(248,809.00)	54%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180,000.00	-	(180,000.00)	0%
210807	Газрын төлбөр	2,879,500.00	2,879,520.00	20.00	100%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	29,500.00	(70,500.00)	30%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	23,480,000.00	23,462,090.00	(17,910.00)	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,566,400.00	9,496,600.00	(69,800.00)	99%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,566,400.00	9,496,600.00	(69,800.00)	99%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,640,000.00	4,493,477.00	(4,146,523.00)	52%
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,640,000.00	4,493,477.00	(4,146,523.00)	52%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,640,000.00	4,493,477.00	(4,146,523.00)	52%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,770,005,200.00	10,911,845,278.16	(1,858,159,921.84)	85%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	1,520,115,860.00	1,520,115,860.00	
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	1,520,115,860.00	1,520,115,860.00	
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,043,530,700.00	8,956,353,102.00	(3,087,177,598.00)	74%
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,043,530,700.00	8,956,353,102.00	(3,087,177,598.00)	74%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	726,474,500.00	435,376,316.16	(291,098,183.84)	60%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	678,385,300.00	378,344,514.00	(300,040,786.00)	56%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,089,200.00	57,031,802.16	8,942,602.16	119%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,878,546.83	10,878,546.83	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	487.00	487.00	-	100%
620001	Удирдах ажилтан	7.00	7.00	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	344.00	344.00	-	100%
620003	Үйлчлэх ажилтан	136.00	136.00	-	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,024,726,693.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,024,726,693.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	382,285,523.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	338,875,702.00
210101	Үндсэн цалин	338,875,702.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,409,821.46
210201	Тэтгэврийн даатгал	43,409,821.46
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,141,170.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,141,170.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	628,300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	628,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	628,300,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,034,826,693.46
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,034,826,693.46
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,025,738,304.46
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,088,389.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	10,100,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,100,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Нийслэлийн Өргөө амаржих газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй, дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Солонготуяа, аудитор А.Жамъян нар гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер Н.Алтанзул, Нийслэл дэх Төрийн аудитын газрын аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Өргөө амаржих газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Монголиан Бизнес Рейтинг Аудит" ХХК-д 2022 оны 02 дүгээр сарын 14-ний өдрийн 54 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийслэлийн Өргөө амаржих газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь *"Нотолгоонд суурилсан нөхөн үржихүйн эрүүл мэндийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг стандартын дагуу хүртээмжтэй чанартай, сэтгэл ханамжтай хүргэж эсэн мэнд амаржуулах үйл явцыг олон улсын жишигт хүргэх."* гэж тодорхойлжээ.

Нийслэлийн Өргөө амаржих газрын үйл ажиллагааны зорилго нь "Хууль эрх зүйн хүрээнд эх эмэгтэйчүүд, нярай, мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлж эсэн мэнд амаржуулахад оршино."

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам";
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай";
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай";
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар";
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. "Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268 дугаар тушаалаар баталсан “Ковид-19”-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээг батлах тухай”, 2021 оны А/387/99 дугаар тушаалуудаар батлагдсан “Журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах” шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын комисс нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, хяналт хийж, тайланг захирлын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Өргөө амаржих газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 13,532,395.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 135,324.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 108,259.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийслэлийн Өргөө амаржих газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 911,524.7 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	20,978.5	20,978.5
Авлага	-	641,210.2	641,210.2
Бараа материал	738,508.2	798,316.2	59,808.0
Биет хөрөнгө	19,712,061.0	19,911,152.4	199,091.4
Биет бус хөрөнгө	444,404.5	444,350.7	(53.8)
Нийт хөрөнгө	20,904,483.4	21,816,008.1	911,524.7
Богино хугацаат ер төлбөр	162,060.9	1,003,568.7	841,507.8
Засгийн газрын хувь оролцоо	20,742,422.5	20,812,439.4	70,016.9
Хуримтлагдсан үр дүн	6,262,966.0	6,333,029.3	70,063.3
Нийт ер төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	20,904,483.4	21,816,008.1	911,524.7

Бараа материалын дансны үлдэгдэл 798,316.2 мянган төгрөг болж 59,808.0 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд 3,039,372.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 445,762.8 мянган төгрөгийн бараа материал хандив, тусламжаар хүлээн авч 3,309,671.0 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 199,091.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 97,057.8 мянган төгрөгийн барилгын сайжруулалт, 1,301,681.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хандив тусламжаар хүлээн авч, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны А/140 дугаар тушаалаар элэгдлээрээ өртгөө нөхсөн 499,671.2 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассанаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 53.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны 53.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Богино хугацаат ер төлбөр дансны үлдэгдэл 841,507.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангийн эмийн санхүүжилтийн авлага барагдаагүйгээс эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгч компаниудад 981,230.9 мянган төгрөгийн өгөх өглөг үүссэнээс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 6,333,029.3 мянган төгрөг болж 70,063.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 2,497,732.4 мянган төгрөгөөр буюу 18.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж, бараа материалын зардал, нормативд зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа ажил үйлчилгээний бусад зардал, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардал байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 654,375.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 130,662.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 98,681.8 мянган төгрөг, нормативт зардал 847,558.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 90,809.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын 81,848.0 мянган төгрөгийн өсөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

ХАК-2022/794/НА-СТА-ТШЗ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 17,102,189.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 17,102,189.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 4,332,184.5 мянган төгрөгөөр бууруулж 12,770,005.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 12,770,005.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 12,043,530.7 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 678,385.3 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 48,089.2 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,520,115.9 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 8,956,353.1 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогоос 435,376.3 мянга, Засгийн газрын нөөц сангаас 780,000.0 мянга, Эрдэнэс таван толгой ХК-аас 725,000.0 мянга, Эрүүл мэндийн яамнаас 150,000.0, нийт 12,566,845.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 12,555,966.7 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 10,878.6 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 12,555,966.7 мянган төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь цалин түүнтэй адилтгах зардал 2,536.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 992.6 мянган төгрөг, нормативд зардал 205,535.6 мянган төгрөг, томилолтын зардал 1,652.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 2,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,025,738.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7,088.4 мянган төгрөг, нийт 1,034,826.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон шимтгэлийн зардалд 382,285.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 14,141.2 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 628,300.0 мянга, нийт 1,024,726.7 мянган төгрөгийг зарцуулж, 10,100.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268 дугаар тушаалаар баталсан “Ковид-19”-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээг батлах тухай”, 2021 оны А/387/99 дугаар тушаалуудаар батлагдсан “Журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах” шийдвэрүүдийн дагуу Нийслэлийн Өргөө амаржих газар нь үндсэн үйл ажиллагааг гүйцэтгэхийн зэрэгцээ Коронавируст цар тахлын тусламж үйлчилгээг үзүүлж тайлант онд Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үеийн цогц тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн хүрээнд коронавируст халдвараар хэвтүүлэн эмчилсэн 1899 ХАК-2022/794/НА-СТА-ТШЗ

иргэний эмчилгээний төлбөр 2,219,695.0 мянга, дархлаажуулалтад хамруулсан 838 иргэний төлбөр 4,190.0 мянга, тандалтаар 87 иргэний 435.0 мянга, нийт 2,224,320.0 мянган төгрөгийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлж, нэхэмжлэхийг ЭМДС-аас хянаж, 8,956,353.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 629,849.8 мянган төгрөгийн авлагатай байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлтийн 981,230.9 мянган төгрөгийн өглөгтэй байна. Эдгээр авлага, өглөгийг 2022 оны 1-р сард бүрэн барагдуулсан тул уг авлага, өглөгийг зөрчилд тооцсонгүй.

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал гараагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 2,482,320.0 мянган төгрөгийн мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж харин 28 мэдээллийг хугацаа хоцроосон, 3 мэдээллийг огт оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.4, 6.5.6 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журмыг хэрэгжүүлж ажилласан нь Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268, А/387/99 дугаар тушаалуудаар батлагдсан шийдвэрүүдийн холбогдох заалттай нийцсэн.
- Тайлант онд түрээслүүлэгч Нийслэлийн Өргөө амаржих газар нь түрээслэгч ТЭХНХ ХХК-тай байгуулсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ"-нд заасан түрээсийн төлбөр 10,423.4 мянган төгрөгийг түрээслэгч тал төлөөгүй нь 2020 оны 060916 дугаар бүхий "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ"-ний холбогдох заалттай нийцэхгүй байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

3.10.1 Завсрын аудитын үр дүн:

2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 8,732.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8,732.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 8,732.2 мянган төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.10.2 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 428,369.4 мянган төгрөгийн зөрчилд 428,369.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг өгсөн.

Аудитаар өгсөн 428,369.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт:

мянган төгрөг

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	2	428,369.4	2	428,369.4			
Нийт дүн	2	428,369.4	2	428,369.4			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Түрээслүүлэгч Нийслэлийн Өргөө амаржих газар нь түрээслэгч ТЭХНХ ХХК-тай байгуулсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ"-нд заасан түрээсийн төлбөр 10,423.4 мянган төгрөгийн авлага нь шүүхийн шатанд хянагдаж байгаа тул дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 39,295.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10,423.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 28,872.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй тул баталгаажуулав.

4.2 Албан шаардлага

Тайлант онд түрээслүүлэгч Нийслэлийн Өргөө амаржих газар нь түрээслэгч ТЭХНХ ХХК-тай байгуулсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ"-нд заасан түрээсийн төлбөр 10,423.4 мянган төгрөгийг түрээслэгч тал төлөөгүй нь 2020 оны 060916 дугаар бүхий "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ"-ний 2.5-д "Түрээслүүлэгч болон түрээслэгчээс гэрээний үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж ажиллана, "Иргэний хуулийн 318.1-д "Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн орлогыг бүрэн төвлөрүүлж авах албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого төвлөрүүлэлттэй холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогыг 678,385.3 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 378,344.5 мянган төгрөгийн буюу 55.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. **Өгсөн зөвлөмж:** Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж ажиллах.

2. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

2.1 **Илрүүлэлт:** Тайлант онд 25 ААН-ээс худалдан авалт хийсэн гүйлгээг татварын цахим бүртгэлийн систем дэх төлбөрийн баримттай тулган шалгахад 9 ААН-ээс 28,872.0 мянган төгрөгийн цахим баримт зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

2.2 **Өгсөн зөвлөмж:** Хууль тогтоомжийг хэрэгжүүлж татварын цахим төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллага болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

----oOo----

Бэлтгэсэн:

"Монголиан бизнес рейтинг аудит" ХХК-ийн

Ерөнхий захирал

Аудитор



Д.Түмэнжаргал

Б.Солонготуяа

ГНИСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Зөрчлөмж			
					Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар										
1	Нийслэлийн Өргөө амаржих газар	ХАК-2022/794/Н А-СТА-ТШЗ	Тайлант онд түрээслүүлэгч Нийслэлийн Өргөө амаржих газар нь түрээслэгч ТЭХНХ ХХК-тай байгуулсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ"-нд заасан түрээсийн төлбөр 10,423.4 мянган төгрөгийг түрээслэгч тал төлөөгүй	Албан шаардлага хүргүүлэх.	1	10,423.4	1	10,423.4		
2	Нийслэлийн Өргөө амаржих газар	ХАК-2022/794/Н А-СТА-ТШЗ	Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогыг 678,385.3 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 378,344.5 мянган төгрөгийн буюу 55.8 хувийн гүйцэтгэлтэй байна.	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.	1	-	1	-		
4	Нийслэлийн Өргөө амаржих газар	ХАК-2022/794/Н А-СТА-ТШЗ	Тайлант онд 25 ААН-ээс худалдан авалт хийсэн гүйлгээг татварын цахим бүртгэлийн систем дэх төлбөрийн баримттай тулган шалгахад 9 ААН-ээс 28,872.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй	Татварын цахим төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах.	1	28,872.0	1	28,872.0		
Дүн					3	39,295.4	1	10,423.4	2	28,872.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал										
5	Нийслэлийн Өргөө амаржих газар	ХАК-2022/794/Н А-СТА-ТШЗ	Шилэн дансанд 28 мэдээллийг хуулийн хугацаа хоцроосон, 3 мэдээллийг огт оруулаагүй.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.	1	-	1	-		
Дүн					1	-	1	-		
Нийт дүн					4	39,295.4	3	28,872.0		